

**БАТЛАВ.  
САНГИЙН САЙД**

**БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Б.ЖАВХЛАН**

**Х.НЯМБААТАР**

## **БООЦООТ ТААВАР, ХОНЖВОРТ СУГАЛААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл болон практик шаардлага байна. Үүнд:

#### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн хувийн аж ахуй эрхлэх эрхтэй.” гэж заасан.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.4 болон 15.5.8-д зааснаар эд мөнгөний хонжворт сугалаа гаргах үйл ажиллагаа болон төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд уг хуулиар тусгай зөвшөөрлийн агуулга, үйлчлэх хүрээ, хугацаа, сунгалт, олгох журам, зөвшөөрөл олгоход баримтлах зарчим, шаардлага, бүрдүүлэх баримт бичиг зэрэг нийтлэг журмыг тогтоосон. Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой татвар, хураамжийн асуудлыг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Онцгой албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиудын холбогдох зүйл, заалтуудаар зохицуулсан байна.

Харин тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “тухайн төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг тус тусын хуулиар зохицуулна.” гэж заасны дагуу эдгээр үйл ажиллагаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхлэх үйл ажиллагаатай холбогдуулан хүлээх эрх, үүрэг, шаардлагыг зохицуулах нарийвчилсан хууль батлагдаагүй нь энэхүү хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

#### **1.2.Практик шаардлага**

Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад иргэн, аж ахуйн нэгжээс ирдэг боловч казино, мөрийтэй тоглоом, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалаа зэргийн хоорондын ялгаа, эдгээрт ямар тоглоом хамаарах, үйл ажиллагаандаа ямар дүрэм, журмыг мөрдөх,

юуг хориглох зэргийг тодорхойлсон хууль байхгүйн улмаас 2006 оноос хойш ийм төрлийн тусгай зөвшөөрлийг олгоогүй байна.

Харин цахим орчинд казиногийн тоглоом, спортын болон бусад төрлийн бооцоот тоглоом эрхэлдэг гадаадын хуулийн этгээдийн үйл ажиллагаа Монгол Улсын хүн амын дунд түгээмэл болсон байгаа нь зайлшгүй шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал болж байна.

2021 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд бооцоот тоглоомын вэбсайтад хандаж, бооцоо тавьдаг хэрэглэгчдийн тоо 100 мянга давсан бөгөөд үүнээс идэвхтэй хэрэглэгчдийн тоо 15,000-20,000 байна гэсэн албан бус судалгаа байна. Мөн тус албан бус судалгаанд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 20 гаруй агент буюу зуучлагч байна гэсэн бөгөөд эдгээр агентаар дамжин Монгол Улсаас гарч байгаа мөнгө нь нэг сард 10 тэрбум, түүнээс дээш хэмжээний төгрөгт хүрээд байна гэсэн байна.

Үндэсний статистикийн хорооны судалгаанд 2020 оны байдлаар эдийн засгийн гэмт хэрэг 123 бүртгэгдэж, нийт 102,8 тэрбум төгрөгийн хохирол учруулсан гэж дурдсан байна.<sup>1</sup> Эдийн засгийн гэмт хэрэг гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цахим болон цахим бус хэлбэрээр хууль бусаар бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулж мөнгө угаах, бооцоот тоглоомоор дамжуулан бусдыг залилах, татвар төлөхөөс зайлсхийх зэрэг гэмт хэргүүд багтаж байна. Харин эдийн засгийн гэмт хэргийн хохирогчийн 13.6 хувийг 18-29 насны иргэд, 38.6 хувийг 30-39 насны иргэд эзэлж байна гэжээ.<sup>2</sup> Бооцоот тааврын үйл ажиллагаа эрхлэх боломж, хуулийн тодорхойгүй байдал, энэхүү зөвшөөрлийг олгох хуулийн заалт байгаа хэдий ч нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаа зэрэг нь гадаад улсын вэбсайтуудаар Монгол Улсын иргэд цахим гэмт хэрэг, залилангийн хохирогч болж, хөрөнгөө их хэмжээгээр алдах эрсдэлийг дагуулж байна.

Цагдаагийн байгууллагаас Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албатай хамтран 2020 онд хууль бус мөрийтэй тоглоомтой холбоотой гүйлгээний талаар судалгаа хийхэд арилжааны 4 банкаар хууль бус мөрийтэй тоглоомын гүйлгээ тогтмол хийгдэж, өдөрт дунджаар 1024 харилцагчийн данснаас 1871 удаагийн гүйлгээ хийгддэг гэх тоон үзүүлэлт гарчээ. Мөн цагдаагийн байгууллагаас 2021 оны эхний 10 сарын байдлаар цахим орчинд хууль бусаар мөрийтэй тоглоом зохион байгуулсан нэр бүхий 226 вэбсайтад Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлаж, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба, Прокурорын байгууллагатай хамтран мөрийтэй тоглоомтой холбоотойгоор төвлөрсөн 227 харилцах дансан дахь нийт 1.5 тэрбум төгрөгийн шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон байна.<sup>3</sup>

Иймд казино, мөрийтэй тоглоом, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалаа зэргийн хоорондын ялгааг тодорхой болгож, тусгай зөвшөөрөл олгох журам, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаандаа

<sup>1</sup> Үндэсний статистикийн хороо: Гэмт хэргийн статистик 2020, 56-р хуудас

<sup>2</sup> Үндэсний статистикийн хороо: Гэмт хэргийн статистик 2020, 55-р хуудас

<sup>3</sup> Цагдаагийн ерөнхий газраас 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр албан бичгээр ирүүлсэн мэдээлэл.

мөрдвөл зохих хэм хэмжээ, биелүүлэх шаардлага, тавих хяналтын талаар хуулиар зохицуулах шаардлагатай байна.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслөөр “бооцоот таавар”, “хонжворт сугалаа” зэрэг нэр томъёог тодорхойлж, ялгааг гаргах бөгөөд эдгээрт ямар тоглоомыг хамааруулахыг тодорхой болгоно.

Түүнчлэн мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг тодорхойлж, ийм төрлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн баримтлах нийтлэг шаардлагуудыг тогтооно.

Мөн хуулийн төслөөр бооцоот таавар болон хонжворт сугалааны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, хариуцлага, хориглох үйл ажиллагаа, төрийн зүгээс тавих хяналтын тогтолцоо болон бооцоот таавар, хонжворт сугалаанд оролцогчийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Мөрийтэй тоглоомын үйл ажиллагаанд төрийн зүгээс тавих хяналтыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэг бүхий Зөвлөлийг байгуулах бөгөөд зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгана.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар бооцоот таавар, хонжворт сугалааны үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох асуудал нь тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд тодорхой болсноор хуулиудын уялдаа холбоо хангагдана.

Түүнчлэн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цахимаар казиногийн тоглоом болон бооцоот таавар эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагааг зохицуулах, хянах, татвар ногдуулах боломжтой болно.

### **Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэх бөгөөд хуулийн төслийг Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон Казиногийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулна.

Энэ хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг дагалдуулан боловсруулна.

---o0o---